

10 дугаар ангийн “Биологи” хичээлийн

анги дэвших шалгалт

Сонгох даалгавар

1. Хорхойн бүлгийн хүрээнүүдийн ерөнхий шинжийг зөв харгалзуулаарай. /1 оноо/

- | | | | |
|-------------------|--|---------------|---------------|
| 1. Хавтгай хорхой | A. Шимэгч хорхой эзэн солихгүй | | |
| 2. Дугариг хорхой | Б. Бие нь нуруу хэвлүү талаасаа хавчгар | | |
| 3. Гархит хорхой | В. Бие нь олон үенүүдээс тогтох ба параподитай | | |
| A.1А, 2Б, 3В | Б. 1Б, 2А, 3В | В. 1В, 2А, 3Б | Г. 1А, 2В, 3Б |

2. Дараах амьтад хөөвчтөний хүрээний ямар ангийн төлөөлөгч вэ? Зөв харгалзуулаарай. /1 оноо/

- | | |
|-----------------------|-----------------------------|
| 1. Загас | A. Гүлмэр, саламандар |
| 2. Хоёр нутагтан | Б. Матар, яст мэлхий |
| 3. Мөлхөгчид | В. Тул, зэвэг, хадран |
| 4. Шувуу | Г. Сарьсан багваахай, зараа |
| 5. Сүүгээр бойжигчид | Д. Хөтүү, ногтруу |
| A. 1Д, 2Б, 3А, 4В, 5Г | Б. 1В, 2Б, 3А, 4Д, 5Г |
| В. 1В, 2А, 3Б, 4Д, 5Г | Г. 1А, 2В, 3Б, 4Г, 5Д |

3. Зураг дээрх амьтан бол..... юм. /1 оноо/



- A. 4 хос хөлтэй, трахейгаар амьсгалдаг толгой цээж хэвлүй гэсэн хэсэгтэй
- B. 3 хос хөлтэй, далавчтай, трахейгаар амьсгалдаг, бие нь 3 хэсэгтэй
- C. 5 хос хөлтэй, далавчтай, уушгиар амьсгалдаг, бие нь 2 хэсэгтэй
- D. 4 хос хөлтэй уушгиар амьсгалдаг, бие нь 3 хэсэгтэй


4. Энзим доорх химиийн бүлгийн аль төрөлд нь багтах вэ? /1 оноо/

- A.Нүүрс-Ус Б.Өөх тос В.Уураг Г.Сахар

5. Бодисын молекуулуд их концентрацтайгаас бага концентрацтай руу өөрөө аяндаа нэвчих үзэгдлийг , уусгагчийн молекул бага концентрацтайгаас их концентрацтай руу хагас нэвтрүүлэгч ханаар нэвтрэхийг –ийн үзэгдэл гэнэ. / 2 оноо/

- A.Оsmos, диффуз Б.Оsmos, сонгон нэвтрэх
B.Диффуз, осмос Г. Сонгон нэвтрэх, диффуз

6. Дараах графикийг сайтар ажиглаад “A” энзим хоол боловсруулах замын аль хэсэгт байдаг энзим болохыг заа. / 2 оноо/



- A. Бүдүүн гэдэс
B. Амны хөндий
C. Нарийн гэдэс
D. Ходоод

7. Хэрэв эсийг түүний вакуоль дахь эсийн шүүсний концентрааас илүү концентрацтай уусмалд байлгаад микроскоп харахад протопласт нь эсийн хананаас хөндийрсөн байдаг. Протоплазм нь эсийн бүрхүүлээс салж хөндийрхөг үзэгдлийггэнэ. /1 оноо/


А.Деплазмолиз

Б.Изотоник

В.Плазмолиз

Г.Гипотоник

8. Сурагчид дараах туршилтыг хийжээ. Туршилт юуг харуулж байна вэ? /1 оноо/



- A. Осмос
Б. Диффуз
В. Эндоцитоз
Г. Плазмолиз

9. Хоол хүнсний холимгийг ходоодны шүүстэй хольж, 37С температурт байлгав. Цагийн дараа дараах бодисуудын аль нь задарч эхлэх вэ? /1 оноо/

А.Эрдэс

Б.Өөх тос

В.Нүүрс ус

Г.Ураг

10. Аль нь фотосинтезэд шаардлагагүй вэ? /1 оноо/



А. Нарны гэрэл

Б.Хүчилтөрөгч

В.Нүүрсхүчлийн хий

Г. Ус

11. Аэроб амьсгалыг урвалын тэгшитгэлээр илэрхийлээрэй. / 1 оноо /



12. Бөөр унжилт нь өндөр туранхай хүмүүст тохиолддог. Бөөр унжихаас хэрхэн сэргийлж болох вэ? / 1 оноо /

А. Жингээ нэмэх

Б. Бүс бүслэх

В. Өвчин намдаах эм уух

Г. Хоол сайн идэх


13. 1, 2, 3 дугаараар тэмдэглэсэн эрхтэнг нэрлээрэй. /1 оноо /

А. 1-бөөр, 2-шээсний суваг, 3-давсаг

Б. 1-бөөрний дээд булчирхай, 2-шээсний суваг, 3-давсаг

В.1-бөөр, 2-шээсний суваг, 3-өндгөвч

Г. 1- өндгөвч, 2-шээсний суваг, 3-давсаг



14. . Дараах ойлголтуудын аль нь нейроныг тодорхойлж байна вэ?

Зөв хариултыг сонгоно уу? /1 оноо/

А. Нейрон нь том, эс завсрлын бодис багатай.

Б. Нейрон нь бүрхүүл, бөөм, сийвэнгээс тогтоно.

В.Нейрон нь аксон, шилбүүрээс тогтдог, агших, сунах чадвартай.

Г.Нейрон нь урт, богино сэргтэнтэй, тархи, нугасны бор, цагаан бодисыг бүрдүүлнэ.

15. Дараах дотоод шүүрлийн булчирхайнуудын зураг дээр бөөрний дээд булчирхайг хэд дугаараар тэмдэглэсэн бэ? /2 оноо/



- A. 2 Б. 7
B. 8 Г. 1

16. Доорх нөхцлүүдийн аль нь сүрьеэгээр өвчлөх эрсдлийг нэмэгдүүлэх вэ? /1 оноо/

1. ариутгаагүй сүү уух
2. хаягдал усанд амьдарч буй хавч хэлбэртнийг хүнсэнд хэрэглэх
3. хүн амын хэт нягтралтай нөхцөлд амьдрах

A.1 ба 2 Б.1 ба 3 В.2 ба 3 Г. зөвхөн 3

17. Өвчин үүсэх зарим шинжүүдийг жагсаан бичижээ. /1 оноо/

- 1.эцэг эхээс уdamшиж болно. 2.дамжуулагчаар зөөвөрлөгдж болно.
3.стрессээс шалтгаалан үүсч болно. 4.хүрэлцэх үед дамжиж болно.
5.хоол хүнстэй хамт амаар дамжин орж болно.

Эдгээрээс аль нь халдварт өвчний шинжүүд вэ?

A.1,2 ба 3 Б.1,3 ба 5 В.2,3 ба 4 Г.2,4 ба 5

18. Антибиотикоор эмчлэгддэг өвчнийг олно уу. /1 оноо/

- A. холер болон сүрьеэ Б. ХДХВ/ДОХ болон цагаан бурхан
B. ХДХВ/ДОХ болон сүрьеэ Г. Цагаан бурхан болон холер

19. Хүний хромосомын диплойд бүрдэл хэд байдаг вэ? /1 оноо/

A. 23 Б.23 хос В. 46 Г. 46 хос

20. Хромосомын тухай нэр томьёог тодорхойлсон өгүүлбэртэй нь харгалзуулна уу?
/2 оноо/

- 1.Аутосом a. Зүйл бүрд ялгаатай байх хромосомын бүрдэл
2.Бэлгийн хромосом b. Хүйсийг тодорхойлогч 23-р хос хромосом
3.Гомолог хромосом c. Хэлбэр, хэмжээ бүтцийн хувьд ижил хромосомууд
4.Кариотип d. Эрэгтэй эмэгтэй хүнд байх эхний 22 хромосом
A.1a 2b3c4d Б. 1d 2c3b4a В. 1d 2b3c4a Г. 1c 2a3b4d

21. Байгалийн шалгарал, зориудын шалгарал хоёр хоорондоо юугаараа төстэй вэ? /1 оноо/

- A. Үр дүн нь ижил хугацаанд илэрдэг. Б. Удамших хувьсалтай байдгаараа
B. Хөдөлгөгч хүчин нь ижил Г. А ба Б зөв

22. Хромосомын онолд тохирох заалтыг сонгоорой. /1 оноо/

1. Хромосомын онолыг Т.Морган боловсруулсан.
2. Энэ онолыг Г.Мендель нээсэн.
3. Удамшлын хүчин зүйл болох генүүд хромосом дээр байрлана.
4. Генүүд хромосом дээр зэрэгцэж байрлана.
5. Нэг хромосом дээр байрлах генүүд хамт удамшина.

- A. 1,2,4 Б. 1,3,5 В.2,3,4 Г.2,4,5

23. Дор өгөгдсөн нэр томъёонд (1-5) аль тодорхойлолт (А-Д) тохирохыг сонгоно уу? /2 оноо/

1.	Аллель генүүд	А	Нэг аллель генийн илрэл нөгөө аллелийнхаа илрэлийг давамгайлах
2.	Удамшил	Б	Тухайн бодгалийн бүх шинж тэмдгийн нийлбэр
3.	Гетерозигот	В	Өөрийн шинж тэмдгээ дараагийн үе удамдаа шилжүүлэх амьд бие махбодын үндсэн шинж
4.	Давамгайлал	Г	Гомолог хромосомуудын ижил хэсгүүд дээр байрлан нэг шинж тэмдгийн хөгжлийг хариуцах генүүд
5.	Фенотип	Д	Аллель генүүд нь ялгаатай байх бодгаль

- A. 1А, 2Б, 3В, 4Г, 5Д Б. 1Б, 2А, 3В, 4Д, 5Г

- В.1Г, 2В, 3Д, 4А, 5Б Г. 1Д, 2Г, 3А, 4В, 5Д

24. Гетерозигот бодгалийг тэмдэглэсэн тэмдэглэгээ аль нь вэ? /1 оноо/

- A. Ab Б. AA В. Aa Г. aa

25. Хүний үсний хар өнгө нь бор өнгөө давамгайлдаг. Эцэг эх хар үстэй гэр бүлээс бор үстэй хүүхэд төржээ. Эцэг эхийн генотип аль нь вэ? /2 оноо/

- A.GG X gg Б. Gg X gg В. gg x gg Г. Gg x Gg

26. Инсулины үйлдвэрлэлтэй холбоотой дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1.Инсулины генийг ялгах	А. ДНХ-ийн цагираг молекулыг тасалж төгсгөлд нь цитозин бүхий нуклеотидыг нэмнэ.
2.Генийг векторт оруулах	Б. Инсулины мэдээлэл бүхий мРНХ-ийн ялган авч комплементарь зарчмаар ДНХ-г бий болгоно
3.Генийг бактерийн эсэд оруулах	В. Хүний инсулины гентэй бактериудыг тусгай төхөөрөмжинд хийж есгевэрлнэ.
4. Инсулин үйлдвэрлэх	Г. Инсулины ген бүхий плазмидыг бактерийн эсүүдтэй хольж плазмидыг авсан нянг ялган авна.

- А.1Б, 2А, 3Г, 4В Б.1А, 2Б, 3В, 4Г В. 1Г, 2В, 3Б, 4А Г.1А, 2Б, 3Г, 4В


27. Эдгээр бичил биетийн алийг нь пенициллины үйлдвэрлэлд ашигладаг вэ? /1 оноо/

- A. Сүүн хүчлийн бактери Б.Хөгц мөөгөнцөр
B. Гэдэсний савханцар Г.Хөрөнгөний мөөг

28. Аэроб амьсалаар глюкоз задарчээ. Энэ процессоор үүссэн бодисууд ямар эргэлтэнд оролцох вэ? /1 оноо/

- A.Нүүрстөрөгчийн эргэлт Б.Нүүрстөрөгч болон усны эргэлт
В. Зөвхөн усны эргэлт Д.Энергийн болон усны

29. Популяцын ангилалын зургийг ажиглаж аль нь эгэл популяци болохыг сонгоно уу?
/2 оноо/



- A.1 Б.2 В.3 Г.4

30. Нэг га ойн талбайд 320 ширхэг шинэс ургасан байх, $1m^3$ усанд 0,9 грамм дафни амьдардаг зэрэг нь популяцийн аль үзүүлэлтийг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- А. Нягтшил Б.Тоо толгой В. Төлөрхөг чанар Г.Цэвэр өсөлт

31. Биосфериийн бохирдлыг жишээтэй нь зөв харгалзуулна уу. /1 оноо/

1. Биологийн a. Атомын цахилгаан станцын осол гарах
2. Шуугианы b. Мөнгөн ус нь удамшлын тогтолцоог гэмтээн ургийн гажиг үүсгэх
3. Химийн c. Тарваган тахлаар өвдөх
4. Цацрагийн d. Машины дуут дохио дуугарах

- А. 1a 2b 3d 4c Б. 1b 2c 3d 4a В. 1c 2a 3c 4d Г. 1c 2d 3b 4a

32. Ойг их хэмжээгээр устгаснаас агаарын найрлага дахь хүчилтөрөгч, усны уур, нүүрсхүчлийн хийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөхийг үзүүлсэн мөрийг сонгоно уу. /1 оноо/

	Хүчилтөрөгч	Усны уур	Нүүрсхүчлийн хий
А	багасна	ихэснэ	ихэснэ
Б	багасна	багасна	ихэснэ
В	ихэснэ	багасна	багасна
Г	ихэснэ	ихэснэ	багасна

Задгай даалгавар


33. Доорх амьтдыг энгийн түлхүүр ашиглан тодорхойлоорой. / 3 оноо/



- | | |
|--|------|
| 1.далаавчтай | 5 |
| 2.Далаавчгүй | 3 |
| 3.5 хос хөлтэй, урд 2 нь хавчуур болсон Хавч | |
| 4. 4 хос хөлтэй | Аалз |
| 5.3хос хөлтэй | Шавж |

Хариулт: 1. 2..... 3.....

34. Дараах зургийг тодорхойлолттой нь зөв холбоно уу? /4 оноо/



- 1.Эсийн шүүсний концентраас их концентрацтай уусмал
2. Эсийн шүүсний концентрацтай тэнцүү концентрацтай уусмал
3. Эсийн шүүсний концентраас бага концентрацтай уусмал

35. А. Аав нь 3-р бүлгийн цустай, ээж нь 2-р бүлгийн цустай гэр бүлд мэндэлсэн 4 хүүхэд бүгд өөр өөр бүлгийн цустай байсан бол аав ээжийн цусны генотипийг олно уу. /4 оноо/

- A. $I^B I^B \times I^A I^O$ B. $I^B I^B \times I^A I^A$ C. $I^B I^O \times I^A I^O$ D. $I^B I^O \times I^A I^A$

Б. Хүүхэд тус бүрийн генотипийг бичнэ үү?

.....

36. Байгаль дах нүүрстөрөгчийн эргэлтийг бүдүүвчээр үзүүлжээ. Амьсгал явагдаж байгаа үе шатуудын үсгэн тэмдэглэгээг бичнэ үү. /3 оноо/

